



МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

2025

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ
(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТӨСЛИЙГ
БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН СУДАЛГАА

АГУУЛГА

Нэг. Удиртгал

Хоёр. Асуудалд хийсэн дүн шинжилгээ

Гурав. Асуудлыг шийдвэрлэх зорилго

Дөрөв. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг тал

Тав. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөний тандан судалгаа

Зургаа. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулсан дүгнэлт

Долоо. Зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн
зохицуулалтын харьцуулсан судалгаа

Найм. Зөвлөмж

НЭГ. УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн найруулах асуудалд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” (цаашид “аргачлал” гэх)-ыг баримтлан доорх тандан судалгааг хийв.

Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Хөгжлийн банк” гэх)-ыг Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоолоор² үүсгэн байгуулж, дүрмийг баталсан. Улсын Их Хурлаас 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг³ баталж, Засгийн газрын 2011 оны 151 дүгээр тогтоолоор⁴ Хөгжлийн банкны дүрмийг шинэчлэн баталжээ.

Хөгжлийн банкны засаглалыг сайжруулах, хараат бус, бие даасан байдлыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх зорилгоор 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдөр тус хуулийн шинэчилсэн найруулгыг⁵ баталсан бөгөөд хамгийн сүүлд 2021 оны 252 дугаар тогтоолоор⁶ Хөгжлийн банкны дүрмийг шинэчлэн баталсан.

Монгол Улсын Хөгжлийн банк үйл ажиллагаа явуулсан 11 жилийн хугацаанд чанаргүй зээлийн хэмжээ эрс өссөн. Шалтгаан нь 2016 оныг хүртэл тус банкны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг УИХ, ЗГ-аас баталдаг байсан, 2017 оныг хүртэл Төв банкны хяналтад байгаагүй, Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүдийн томилгоо тогтворгүй байсан, ТУЗ-ийн гишүүдийн 4 нь хараат бус байх хуультай боловч, гишүүдийг сонгон шалгаруулах ажиллагааг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч яам зохион байгуулдгаас ТУЗ-ийн гишүүдийн хараат бус байдал алдагдсан, Гүйцэтгэх удирдлага өөрийн багаа бүрдүүлж ажиллах боломжгүй байсны улмаас хүний нөөцийн бодлого тогтворгүй, алдаатай байсан зэрэгтэй холбоотой юм.

Хөгжлийн банканд 2015-2021 оны хооронд төрөөс нийт 10 удаагийн хяналт шалгалт хийсэн бөгөөд давхардсан тоогоор 189 зөрчил илрүүлж зөвлөмж өгсөн. Гэвч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил дутагдлыг арилгах талаар бодитой арга хэмжээ авдаггүй, тайлагнадаггүй байсан.

Эдгээр нөхцөл байдалд үндэслэн Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайланд дурдсаны дагуу, Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн найруулах талаар нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай болсон.

¹“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=5466>

³“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 9 дугаарт нийтлэгдсэн.

⁴ <https://legalinfo.mn/mn/detail/3278/2/202872>

⁵“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 9 дугаарт нийтлэгдсэн.

⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231084129981>

ХОЁР. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Монголбанкнаас Хөгжлийн банканд 2021 онд хийсэн хяналт шалгалтын үр дүнгээр банкнаас олгосон зээлийн багцын 55.3 хувь буюу 3.2 их наяд төгрөгийн дүн бүхий актив чанаргүй ангилалд шилжсэн нь тогтоогдсон бөгөөд Хөгжлийн банк 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар банкны чанаргүй активын талаар олон нийтэд нээлттэй зарласан. Тухайн үед чанаргүй активын улмаас банкны гадаад улсаас татан төвлөрүүлсэн бондын болон зээлийн эргэн төлөлт хангагдахгүйд хүрч, дефолт болох эрсдэл үүссэн байсан.

Хөгжлийн банкиг 16.7 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр анх байгуулсан бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 8 удаа хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж 1.2 их наяд төгрөгт хүргэсэн. Хөгжлийн банкнаас өнгөрсөн хугацаанд нийт 3,000 гаруй төсөл, хөтөлбөрүүдэд 7.6 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилт олгосон. Одоогийн байдлаар зээлийн багцын үлдэгдэл нь 40 зээлдэгчийн 2.2 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа ба үүнээс 57.5 хувь буюу 1.3 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь чанаргүй ангилалд байна. Чанаргүй активын 57.1 хувийг өмнөх 2011 оны хуулийн хүрээнд олгосон зээлийн багцын үлдэгдэл, 42.9 хувийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд олгосон зээлийн багцын үлдэгдэл эзэлж байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгаар банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг Улсын Их Хурал, Засгийн газраас тусгайлан батлахгүй байх зохицуулалтыг оруулсан хэдий ч банкны төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын аль нь санхүүжилтийн шийдвэр гаргах эрхтэй байхыг хуулиар нарийвчлан тодорхойлоогүй. Банкны бусад хуулиар олгогдсон үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргалтын хуваарилалт, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх үүрэг, шийдвэр гаргалтыг гүйцэтгэх удирдлагаас ялгаатай байлгах нарийвчилсан зохицуулалтгүйгээс бодлогын чиглэл өгч, хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төлөөлөн удирдах зөвлөл нь зээл, санхүүжилт олгох, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах зэрэг банкны өдөр тутмын, үндсэн үйл ажиллагааны шийдвэр гаргах эрх, үүргийг хэрэгжүүлж ирсэн. Үүний үр дүнд Хөгжлийн банкны шийдвэр гаргалт удаашрах, улмаар тохиромжтой цаг үеийн мөчлөгөө алдах, төлөөлөн удирдах зөвлөл гаргасан шийдвэртээ өөрөө хяналт тавих зөрчил үүсэх, гүйцэтгэх удирдлагын хариуцлага сулрах зэрэг олон сул тал бий болжээ.

Нөгөө талаас, Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан этгээдийг хариуцлагатай байлгах, Хөгжлийн банк санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих хангалттай хуулийн эрх хэмжээ байхгүй байсаар байна. Хөгжлийн банкны чанаргүй активын зээлдэгч зээлийн санхүүжилтийг зориулалт бусаар ашигласан, зээлийн зарцуулалт баримтаар нотлогдохгүй, төсөл хэрэгжээгүй тохиолдлууд түгээмэл байгаа нь зээлдэгч болон зээлдүүлэгч нар анхнаасаа төслийг хэрэгжүүлэх санаа зорилгогүй байсан магадлал өндөр байгааг илтгэх ба энэ нь төслийн хэрэгжилтэд тавих хяналт сул, хуулиар хүлээлгэх хариуцлагын тогтолцоо дутмаг байгаагийн илрэл юм. Энэ байдал нь авлига, ашиг сонирхлын зөрчлийг өөгшүүлж, судалгаа шинжилгээ, тооцоололд

суурилсан мэргэжлийн шийдвэр гаргах бус харин хувийн ашиг сонирхолд суурилж, шийдвэр гаргах шалтгаан болж байна.

Монгол Улсад банкнаас санхүүжилт авсан этгээд нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлага сул, шүүхийн процессын урт удаан сунжирсан ажиллагааны улмаас учирсан хохирлыг гаргуулах хууль, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан этгээдүүд нь гэрээний үүргээ хэрэгжүүлж, зээлийг эргэн төлөхөөс зайлсхийж шүүх, хууль сахиулах, хяналтын байгууллагаар хянан шийдвэрлүүлэх замаар асуудлыг сунжруулж, Хөгжлийн банканд учирч буй алдагдлыг улам нэмэгдүүлж байна.

Дээрх нөхцөл байдлуудын үр дүнд Хөгжлийн банкны одоо байгаа зээлийн багцын 57.5% буюу 1.3 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь чанаргүй ангилалд шилжсэн, цаашлаад тус банкны гадаад улсаас татан төвлөрүүлсэн бондын эргэн төлөлт хангагдахгүйд хүрч, дефолт зарлах эрсдэл үүссэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор Хянан шалгах Түр хороог байгуулж, хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд энэхүү Хянан шалгах түр хорооноос дараах зөвлөмжүүдийг өгсөн. Үүнд:

Банкны засаглалтай холбоотой зөвлөмжийн хүрээнд:

- Хөгжлийн банкны засаглал, удирдлагын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх. Банкны хяналтын Базелийн хорооноос 2015 онд баталсан “Банканд зориулсан Компанийн засаглал зарчмууд”, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (OECD)-аас гаргасан “Компанийн засаглалын зарчмууд”, “Төрийн өмчит компанийн засаглал”-ын баримт бичгүүдэд засаглал, удирдлагын тогтолцооны үе шат бүхэнд баримтлах зарчмууд, дотоод хяналт ба эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүтэц, эрх хэмжээг тусгасан засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй тайлбарыг тусгасан байгаа тул эдгээр баримт бичгүүдэд үндэслэн Банкны засаглалын бодлого, Эрсдэлийн бодлогыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх болон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд, сонирхлын зөрчилгүй, хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ийн гишүүдийг томилох, ТУЗ-ийн гишүүдтэй гэрээ байгуулах,

Банкны хяналтын тогтолцоотой холбоотой зөвлөмжийн хүрээнд:

- Олон улсын жишгээр хөгжлийн банкнуудын 72 хувь нь Төв банкны, 28 хувь нь Засгийн газрын хяналтад байгааг харгалзан үр ашигтай, зохистой хяналтын тогтолцоог бий болгох;
- Банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк, санхүүгийн стандартад нийцүүлж, энэ хүрээнд холбогдох эрх зүйн орчин, дүрэм журмуудыг тогтоох;

Дээрх зөвлөмжийн хүрээнд Хөгжлийн банкнийг иж бүрэн өөрчлөн зохион байгуулах бүтцийн өөрчлөлт хийх, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн төслийг боловсруулахыг Засгийн газарт чиглэл болгосон УИХ-ын тогтоол гаргах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 26 дугаар тогтоолоор “ ... хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг хэрэгжүүлж, Хөгжлийн банкнийг цогцоор нь иж бүрэн өөрчлөн зохион байгуулж, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, ... хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, ... холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх” үүргийг Засгийн газарт өгсөн.

2.2. Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн байдал

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга (2017 он)-д санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг Улсын Их Хурал, Засгийн газраас тусгайлан батлахгүй байх зохицуулалтыг тусгасан. Тодруулбал, Хөгжлийн банк мэргэжлийн байгууллагын хувьд Улсын Их Хурал, Засгийн газраас хамааралгүйгээр бие даан шийдвэр гаргаж, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг тус банкны эрх бүхий албан тушаалтан хүлээдэг механизмыг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, хуульд заасан шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг Хөгжлийн банк санхүүжүүлэх шийдвэрийг бие даан гаргахаар зохицуулсан. Гэвч Хөгжлийн банк санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрөө бие даан сонгодог болгосноор санхүүжүүлсэн төслүүд хөгжлийн томоохон төслүүд гэхээс илүүтэйгээр арилжааны банкнаас санхүүжүүлэх боломжтой, тэдний шалгуур, шаардлагыг хангахгүй жижиг (4-20 тэрбум төгрөг) төслүүдийг санхүүжүүлэх болсон.

Монгол Улсын хэмжээнд иргэний хэргийн шүүхийн ачаалал их, голлох хэрэг маргаан нь зээлийн гэрээтэй холбоотой, шүүхийн шийдвэр гүйцэтгэл удаашралтай. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нийт гүйцэтгэвэл зохих баримт бичгийн 70 гаруй хувийг эзэлдэг, түүнчлэн шүүхэд хандсанаас хойш санхүүжилтийг бүрэн эргэн төлөгдөх хүртэл хугацаанд Хөгжлийн банканд учирч буй хохирлыг нэхэмжлэх эрх зүйн зохицуулалтгүй, энэ талаар шийдвэрлэж байсан шүүхийн практик байхгүйгээс Хөгжлийн банк нь олгосон санхүүжилтийнхээ эх үүсвэрийн зардал, чанаргүй активыг бууруулах зардал өсөн нэмэгдсэн боловч өр төлбөрөө барагдуулж чадахгүй ихээр хуримтлуулан улмаар дефолт зарлах эрсдэлд хүргэжээ.

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн зохицуулалтыг илүү нарийвчлан тусгахыг Сангийн сайд, Хууль зүйн сайд нарт даалгасантай холбогдуулан бодлогын түвшинд санхүүжилт, нөөцийг экспортын зах зээл дэх боломж уруу чиглүүлж, худалдаа, экспортын санхүүжилтийн зардлыг бууруулах, экспортын санхүүжилтийн гадаад эх үүсвэрийг татварын суутгал, өөрийн хөрөнгийн доод хэмжээний өндөр шаардлагаас чөлөөлөх, экспортыг дэмжих механизм

болох банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох, экспортын зээлийн баталгаа, батлан даалт гаргах, даатгах, экспортын баримжаатай салбарыг хөгжүүлэхэд эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай юм.

Хөгжлийн банк нь цаашид экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлэх, гадаад худалдааны санхүүжилтийн эх үүсвэр татан төвлөрүүлэх, ЭКСИМ банкны үүргийг хэрэгжүүлэхэд гадаад гуйвуулгын төлбөр тооцоог саадгүй явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8.1.9-т “Экспорт, импортын санхүүжилт хийх” гэж заасан боловч мөн тус хуулийн 17.1-д “Экспорт, импортын санхүүжилт хийх төсөл, хөтөлбөр нь 10.1 (10.1.3 техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн байх г.м)-д заасан шаардлагыг хангасан байх”-аар тусгагдсан нь цаашид гадаад худалдааны санхүүжилтийн төлбөр тооцоотой холбоотой бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, өргөжүүлэх, харилцагчдад санал болгоход хүндрэл үүсгэж болзошгүй болно.

Гадаад худалдааны санхүүжилтийг хийхэд “Худалдааны гэрээ хэлцэл”-д үндэслэн олон улсын стандарт, банкнуудын нэгдсэн журмаар зохицуулагддаг тул Хөгжлийн банк нь урт хугацаанд хөгжлийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, Монгол улсын эдийн засагт нөлөөлөх, эдийн засгийн хямралын үед тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэх зэрэг хөгжлийн банкны үндсэн үйл ажиллагааг эрхлэхэд зарим ойлголтуудыг тодорхой болгох, санхүүгийн арга хэрэгслүүдийг хуульд тодорхой зааж өгөх, санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээг авах харилцагчдад тавих шаардлага, бүрдүүлэх материалыг илүү уян хатан болгох шаардлагатай.

2.3 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

Монгол Улсын Хөгжлийн банканд үүссэн өнөөгийн нөхцөл байдал, цаашид ЭКСИМ банкны чиглэлээр түлхүү үйл ажиллагаа явуулдаг болох Засгийн газраас баримталж буй бодлогын хүрээнд тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь импортыг орлох үйлдвэрлэл болон экспортыг нэмэгдүүлэх, тээвэр логистикийн томоохон дэд бүтцийг бий болгох, эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспорт, импортын санхүүжилтийн зардлыг бууруулах, экспортын санхүүжилтийн гадаад эх үүсвэрийг татварын суутгал, өөрийн хөрөнгийн доод хэмжээний өндөр шаардлагаас чөлөөлөх үр дагаврыг бий болгохоор байна.

Энэхүү үр дагаврын хүрээнд дараах этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөнө:

Хүснэгт 1

№	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
---	-----------------------------	--------------------

1	Иргэд	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөгжлийн банкны тухай хуулийн хүрээнд санхүүжилт авах нь хэдийгээр өндөр шаардлагатай боловч засаглалын тодорхой бус хариуцлагагүй, шийдвэр гаргахдаа нөлөөнд автах, санхүүжилтийг эргэн төлөх сонирхолгүй, зориулалтын бусаар зарцуулж байгаа байдал нь хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөр амжилттай хэрэгжихэд саад учруулж, инфляц нэмэгдэх гэх мэт макро эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.
2	Төр	Хөгжлийн банканд үүссэн өнөөгийн нөхцөл байдлаас улбаалан болзошгүй өр төлбөрийн дарамт нэмэгдэж сөргөөр нөлөөлж байна.
3	Бизнес эрхлэгчид	Монгол Улсын эдийн засагт хувь нэмэр оруулахуйц томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх сонирхолтой, чадамжтай аж ахуйн нэгжүүдэд санхүүжилт олгогдохгүй атлаа санхүүжилтийг эргэн төлөх сонирхолгүй, зориулалтын бусаар зарцуулдаг этгээдүүдэд санхүүжилт олгох боломжтой байгаа нь бизнес эрхлэгчдэд тэгш бус байдлыг бий болгон өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна.
4	Гаднын санхүүжүүлэгчид	Монгол Улсын Хөгжлийн банканд үүссэн өнөөгийн нөхцөл байдлаас улбаалан итгэл алдрах, санхүүжилт олгохоос татгалзах зэрэг нөхцөл байдал үүсэж улмаар олгосон санхүүжилтээсээ алдагдал хүлээх эрсдэлийг бий болгон сөргөөр нөлөөлж байна.
5	Монгол Улсын Хөгжлийн банк	Хөгжлийн банкны засаглалд улс төрийн нөлөө хэт их, тогтвортой бус байгаагаас шалтгаалж үр ашиггүй, эргэн төлөгдөх боломжгүй, шаардлага хангагдаагүй төслүүдэд санхүүжилт олгох улмаар санхүүжилт татах эх үүсвэрийн зардал өсөх, дефолт зарлах зэрэг сөрөг нөлөөтэй байна.

2.4 Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

Хөгжлийн банкны өнөөгийн асуудал нь дараах үндсэн шалтгаанаас үүдэлтэй:

- 1) Хөгжлийн банкны үйл ажиллагааны цар хүрээ, цаашид баримтлах чиглэл, бодлого, эрх хэмжээ, хориглох үйл ажиллагаа тодорхой бус;
- 2) санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрт тавигдах шалгуур тодорхой бус;
- 3) үйл ажиллагаа, засаглалын тогтворгүй байдал, шийдвэр гаргах эрх хэмжээний хуваарилалт тодорхойгүй;
- 4) ил тод бус, хяналтын тогтолцоогүй;
- 5) чанаргүй активыг бууруулах чиглэлээр явуулах үйл ажиллагааг хуульд тодорхой заагаагүй;

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг дараах үндсэн таван чиглэлээр шинэчлэн найруулна оруулна:

1. Хөгжлийн банкны эрх зүйн байдал, зорилго, зорилт, чиг үүрэг, эрх хэмжээг тодорхой болгох;
2. Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн үйл ажиллагааны талаар болон санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт тавигдах шалгуур, хэрэгжих нөхцөлийг тодорхойлох;
3. Засаглалын тогтвортой байдал, шийдвэр гаргах эрх хэмжээг зөв хуваарилах, санхүүжилтийг ил тод болгох;
4. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавигдах хяналтын тогтолцоог тодорхойлох;
5. Эрсдэлтэй активыг бууруулах талаар банкны үйл ажиллагааг боловсронгуй болгох, банканд учрах хохирлын хэмжээг бууруулах;
6. Хууль хоорондын давхардал, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт.

Дээрх агуулгаар хуулийг шинэчлэн найруулснаар Монгол Улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлэхүйц төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж УИХ-ын баталсан Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Зорилго: *“Монгол Улсын Хөгжлийн банкныг цаашид экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн чиглэлээр түлхүү үйл ажиллагаа явуулдаг, засаглалын хувьд тогтвортой ил, тод, хариуцлагатай, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтийг татан төвлөрүүлэх чадвартай мэргэшсэн бодлогын банк болгох бөгөөд санхүүжилт авсан этгээдийг хариуцлагатай, санхүүжилтийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулж, томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх”*

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой дараах хувилбарыг тогтоож, хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судаллаа:

Хүснэгт 2

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн	
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх нь ил тод, нээлттэй байдлыг сайжруулах боловч зорьж буй үр дүнд хүргэхгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан арилахгүй	Үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс	Монгол Улсыг хөгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлогын банктай байх	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж,	Үр дүнд хүрэхгүй

	зохицуулалт хийх	зорилт буюу зохицуулахыг зорьж буй харилцаанд тохиромжгүй.	сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх нь асуудлыг шийдвэрлэхгүй бөгөөд урт хугацаандаа Хөгжлийн банкнийг дефолт зарлах эрсдэлээс сэргийлж чадахгүй. Түр зуурын сэргэлтэд хүргэж болох боловч, урт хугацаандаа банк дампуурах эрсдэлээс сэргийлэх боломжгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан арилахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Монгол Улсыг хөгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх чиг үүргийг шилжүүлэн авах боломжтой санхүүгийн болон хүний нөөцийн чадамжтай төрийн бус байгууллага байхгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналт сайжрах боломж бүрдэх боловч үр дүнд төдийлөн ахиц гарч чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй .	Тодорхой үр дүнд хүрнэ
	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Монгол Улсын Хөгжлийн банкнийг цаашид Экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн чиглэлээр түлхүү үйл ажиллагаа явуулдаг, засаглалын хувьд тогтвортой ил, тод, хариуцлагатай, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтийг босгох чадвартай мэргэшсэн бодлогын банк болгох. авсан санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих боломжтой болсноор Хөгжлийн банкны үйл ажиллагаа үр ашигтай, цаашид Монгол Улсын эдийн засагт эергээр нөлөөлөхүйц томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжтой болно.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаануудыг цогцоор нь шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Дээрх харьцуулалтаас харахад Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль (шинэчилсэн найруулгын)-ийн төсөл боловсруулах нь илүү үр дүнтэй хувилбар мөн.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨНИЙ ТАНДАН СУДАЛГАА

5.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Монгол Улсын макро эдийн засгийн эмзэг, тогтворгүй байдал, төсвийн орлогын савлагаа, түүхий эдээс хамааралтай дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх эдийн засгийн салбаруудын харьцангуй өөр өөр түвшнийг ойртуулах хэрэгцээ шаардлагыг харгалзаж Хөгжлийн банкны эдийн засагт үзүүлэх үр нөлөөллийг Монгол Улсын хөгжлийн зорилтот зах зээл рүү чиглүүлж, экспортыг дэмжих, эдийн засгийн тогтворжуулах, тэнцвэржүүлэх тусгай (төрөлжсөн бус) чиг үүрэгтэй байхаар эрх зүйн байдлыг нь нарийвчлан тодорхойлсноор макро эдийн засаг, инфляц тогтворжиж хүний эрхэд эерэг нөлөө үзүүлнэ.

5.2 Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын хувьд макро эдийн засагт эерэг нөлөө үзүүлж, нийгмийн олон асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг болно.

5.3 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хөгжлийн банкны зорилт нь дотоодын санхүүгийн байгууллагын зах зээл дээр өрсөлдөх бус харин бодлогын банкны хувьд банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн оролцогчидтой хамтарч, тэдний гүйцэтгэж хараахан чадахгүй байгаа сигмент дээр хамтарсан санхүүжилтийн арга хэрэгслээр оролцон санхүүгийн зах зээлийн дутуу орон зайг нөхөж, Монгол улсын санхүү, эдийн засгийн орчны тогтвортой хөгжлийг хангах зорилготой тул эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

5.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөлд тус банк нь тогтвортой, ногоон хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрт шууд болон дамжуулан хэлбэрээр санхүүжилт олгох зохицуулалт туссанаар байгаль орчин уур амьсгалын эрсдэл, доройтлыг багасгахад чиглэсэн буюу байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдлыг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх замаар байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.

Дээрх үр нөлөөнүүдийн талаар дараах хүснэгтээр нарийвчилсан мэдээллийг харуулъя:

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх		Үгүй	Ялгаварлан гадуурхахыг дэмжсэн болон хориглосон зохицуулалт байхгүй.

нийцэж байгаа эсэх	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Нийгмийн аль нэг бүлэг, нэгж, хэсэгт давуу эрх олгохгүй.
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх		Үгүй	Тус хуулийг батлах нь тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилготой арга хэмжээ биш, Монгол Улсын эдийн засгийг сэргээхтэй холбоотой арга хэмжээ болно.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Эмзэг бүлэг, цөөнхийн оролцоог хориглосон зүйлгүй тул тэгш оролцох боломжоор хангагдсан.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Нийт иргэд, төр, байгууллагын эрх, ашиг сонирхолд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шууд бус утгаараа нийт иргэдийн эдийн засгийн эрхийг хангахад чиглэгдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		Хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр тусгана.
	2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	
2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Тийм		Санхүүжилтийг эргэн төлөөгүй, зориулалт бусаар зарцуулсан, нөлөөн автаж шийдвэр гаргасан этгээдийн хувьд хязгаарлалт зайлшгүй болно.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн банк • Засгийн газар • Бизнес эрхлэгч

	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлэгт эмзэг бүлэг байхгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	-
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	-
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Төр, Хөгжлийн банк, Бизнес эрхлэгч
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Жендерийн асуудлыг хөндсөн зохицуулалт тусгаагүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Жендерийн асуудлыг хөндсөн зохицуулалт тусгаагүй тул эрэгтэй, эмэгтэй тэгш боломжтой оролцоно.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Дотоодын эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид давуу байдал олгосон, эсхүл ачаалал үүсгэсэн зохицуулалт агуулаагүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм		Хөгжлийн банк гадаадын банк, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татах боломж нэмэгдэнэ.
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		Эдийн засгийг сэргээхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалт сайжирснаар дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөлөл багасна.
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй

	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		Хөгжлийн банк нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг татах, тэдэнд экспорт болон импорт хийхэд дэмжлэг үзүүлэх бодлогын банк болно.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эдийн засагт эерэг нөлөөллийг авчрах тул хэрэглээний үнийн түвшинд эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		Хөгжлийн банк нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг татах, тэдэнд экспорт

				болон импорт хийхэд дэмжлэг үзүүлэх бодлогын банк болно.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		Эдийн засгийн тогтвортой байдлыг хангаснаар үнийн тогтвортой байдалд нөлөөлж хэрэглэгчдийн эрх ашигт эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Эдийн засгийн өсөлтийг дэмжих тул улсын хэмжээнд ажлын байрыг шинээр бий болгоно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эдийн засгийн тогтвортой байдлыг хангаснаар эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх боломжийг бүрдүүлж өгснөөр бизнесийн орчны таатай байдал бий болох эерэг нөлөө үзүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Хөгжлийн банкны гадаад өрийн дарамт буурч улсын төсөвт учирч болох болзошгүй өр төлбөр буурах эерэг нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм		Хөгжлийн банк нь хуульд заасан үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүтцийн өөрчлөлт хийгдэж болзошгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Хөгжлийн банканд тавих хяналт эрх бүхий төрийн байгууллагууд (Монголбанк, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газар, Улсын Их Хурал г.м)-ын чиг үүрэгт шинээр нэмэгдэх чиг үүрэг байхгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй. Шууд бусаар инфляц буурахад нөлөөтэй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Зөрчилдөх зүйлгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		Үйл ажиллагаа эрхлэх бизнес эрхлэх боломж нэмэгдэх бөгөөд үүнийг дагаад шинэ ажлын байр бий болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг,		Үгүй	Өмнө байсан үүрэг үйл ажиллагаанд өөрчлөлт орохгүй.

мэдээлэл, суртахуун	ёс	үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх			
		4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөл байхгүй.
		4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөл байхгүй.
		4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Нөлөөлөл байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	эрүүл аюулгүй	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Үйлчилгээ сайжирч эерэг нөлөө гарна.
		5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
		5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	эрүүл	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	
		6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
		6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
		6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
		6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	хэрэг, аюулгүй	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.

	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм		Эергээр нөлөөлнө.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Хохирогчид сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 6

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.

	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөгүй.

5.5 Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэх

Тус хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй.

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Дэлхийн нийтийн орчин үеийн чиг хандлага, Хөгжлийн банкны өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэхэд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл боловсруулах хувилбараас бусад хувилбарын хувьд үр дүнгүй байна.

ДОЛОО. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулсан судалгаанд дараах улс орнуудын Хөгжлийн банкны засаглал, шийдвэр гаргах эрх хэмжээний хуваарилалт, санхүүжилт авсан этгээдийн санхүүжилтийг бүрэн эргэн төлөх хүртэл хугацааны хариуцлагын талаар бусад орнуудын хууль тогтоомжийг судлав.

7.1. Экспорт, импортын санхүүжилтийн чиг үүргийг хэрэгжүүлдэг Хөгжлийн банкны туршлага

1. Export Development Canada - Канадын экспортын хөгжлийн банк

Канад Улсын Экспортын хөгжлийн банк нь анх 1944 онд худалдааг нэмэгдүүлэх, Канадын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгуулагдсан, 100% төрийн өмчит байгууллага юм.

Үйл ажиллагааны цар хүрээгээ дараах 3 чиглэлд хуваасан:

- **Эрсдэлийн менежмент:** Эрсдэлийн менежментийн багц үйлчилгээгээр харилцагчийн төлбөр нь худалдааны болон улс төрийн эрсдэлээс хамгаалагдаж бэлэн мөнгөний урсгалыг таслахгүй байх боломжийг олгодог.
- **Баталгаатай санхүүжилт:** Олон улсын томоохон үнэлгээ өндөр төслүүдийг санхүүжилтэд найдвартай туршлагатай түнш бөгөөд зах зээлд өрсөлдөхүйц төлбөрийн нөхцөлтэй санхүүжилт санал болгодог.
- **Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх боломж:** Бонд баталгааны тусламжтай эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломж.

Үйл ажиллагааны чиглэл

- **Эрсдэлийн удирдлага**
 - Зээлийн даатгал
 - Үйл ажиллагааны хамгаалалтын даатгал
- **Санхүүжилтийн шийдэл**
 - Худалдан авагчийн санхүүжилт
 - Шууд зээл
 - Бүтэцлэсэн болон төслийн санхүүжилт
- **Ажлын капиталын шийдэл**
 - Экспортын баталгаа
 - Дансны гүйцэтгэлийн баталгаа
 - Валют солилцооны баталгаа
 - Батлан даалтын бонд

Санхүүгийн товч мэдээлэл

Сая: Канад ам.доллар	2021 он 9 сар
Нийт хөрөнгө	62,920.00
Нийт өр төлбөр	48,818.00
Үйл ажиллагааны орлого	1,309.00
Үйл ажиллагааны зардал	47.00
Татварын өмнөх ашиг/алдагдал	1,262.00
Цэвэр ашиг	1,823.00

Дүрмийн сан	12,300.00
Засгийн газар	100%

Бүтэц зохион байгуулалт

Канадын экспортын хөгжлийн банкны ТУЗ нь тус байгууллагын чиглэл, удирдлагад хяналт тавьж, байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан стратеги чиглэлийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй. ТУЗ нь дарга болон гишүүдээс бүрдсэн нийт 12 хүний орон тооноос бүрдэх ба гишүүдийн дийлэнх хувь нь хувийн хэвшлийн салбараас бүрдсэн байна. ТУЗ-ийн гишүүдийг Канадын Засгийн газраас томилдог бөгөөд Олон улсын худалдааны сайдаар дамжуулан парламентад тайлагнадаг.



2. Japan Bank for International Cooperation - Японы олон улсын хамтын ажиллагааны банк

JBIC нь 2012 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр үүсгэн байгуулагдсан төрийн өмчит бодлогын банк юм. Тус банк нь Япон улсын Сангийн яамны шууд удирдлагад байдаг ба Япон улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалт болон олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэгтэй.

Банк нь дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулснаар Япон улс болон бусад олон улсын эдийн засаг нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой:

- Япон улсын хувьд чухал гэж үзсэн нөөц баялгийг олон улсын тавцанд хөгжүүлэх, баталгаатай болгоход дэмжлэг үзүүлэх;
- Японы үйлдвэрлэлийн олон улсад өрсөлдөх чадварыг хадгалах, нэмэгдүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлт гэх мэт байгаль орчныг хамгаалах зорилго бүхий бизнесүүдийг олон улс руу гарахад дэмжлэг үзүүлэх.


Үйл ажиллагааны чиглэл

- Экспортын зээл
- Импортын зээл
- Гадаадын хөрөнгө оруулалтын зээл

- Untied зээл
- Өмчийн оролцоо
- Баталгаа
- Гүүрэн зээл
- Үнэт цаасжуулалт болон бусад санхүүгийн хэрэгсэл
- Хилийн чанад дахь дэд бүтцийн төслийн талаарх тусгай ажиллагаа
- Өсөлтийн хөрөнгө оруулалтын байгууламж

Бүтэц зохион байгуулалт

Тус банкны дүрэмд заасны дагуу ТУЗ нь 8 гишүүдээс бүрддэг. Үүнд: Гүйцэтгэх удирдлага-6, Яамдаас томилогдсон 2 хараат бус гишүүн байна.



3. China Exim bank – БНХАУ-ын Эксим банк

БНХАУ-ын Эксим банк 1994 онд бие даасан хуулийн этгээд хэлбэрээр байгуулагдсан ба төрийн өмчит бодлогын банк юм. Хятадын гадаад худалдаа, хөрөнгө оруулалт болон олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилготой байгууллага. Хятад улсын үндсэн салбар болон сул хөгжилтэй салбаруудад санхүүгийн дэмжлэг үзүүлснээр улсынхаа тогтвортой эрүүл эдийн засаг нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилттой ажилладаг.


Гадаад худалдаа, cross-border хөрөнгө оруулалт, олон улсын аж үйлдвэрлэлийн чадамжийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг дэмжих, шинжлэх ухаан, тэргүүлэх технологи зэрэгт санхүүжилт олгосноор улс орныхоо тогтвортой хөгжлийн чадамжийг нэмэгдүүлэх зорилготой.

Үйл ажиллагааны чиглэл

Экспортын зээл, импортын зээл, оффшор гэрээ болон гадаадын хөрөнгө оруулалтын зээл, Хятадын засгийн газрын хөнгөлөлттэй зээл, экспортын хөнгөлөлттэй зээл зэрэг гадаад худалдаа буюу "глобалчлагдах" зорилгод нийцсэн богино, дунд болон урт хугацааны зээлүүд олгодог.

Бүтэц зохион байгуулалт

БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс баталсан тус банкны дүрэмд заасны дагуу ТУЗ нь 13 гишүүдээс бүрддэг. Үүнд: Гүйцэтгэх удирдлага-3, (ТУЗ-ийн даргыг оролцуулан), яамдаас томилогдсон 4 гишүүн, хувьцаа эзэмшигчийн 6 гишүүд байна.



4. Export-Import bank of the United States (EXIM) – АНУ-ын Экспорт-Импортын банк (ЭКСИМ)

АНУ-ын ЭКСИМ банк нь 1934 онд экспорт, импортын санхүүжилтийн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилготой байгуулагдсан, 100% төрийн өмчит банк юм.

Тус банкны зорилго нь 1) АНУ-ын бараа, үйлчилгээний экспортын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, 2) АНУ-ын бизнесийг дэлхийн зах зээлд гарахад шаардлагатай хөрөнгө, эх үүсвэрээр хангах, 3) АНУ-ын татвар төлөгчдөд АНУ-ын бараа, үйлчилгээг үнэ төлбөргүй санал болгох замаар “АНУ-д үйлдвэрлэв” бүтээгдэхүүнийг дэмжиж, өрсөлдөөнөөс хамгаалан, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэл

- Шууд зээл
- Экспортын зээлийн даатгал
- Ажлын капитал
- Зээлийн баталгаа
- Төслийн болон бүтэцтэй зээл

- Санхүүгийн түрээсийн баталгаа

Санхүүгийн товч мэдээлэл

Сая: ам.доллар	2021 он 9 сар
Нийт хөрөнгө	16,235.1
Нийт өр төлбөр	16,665.7
Үйл ажиллагааны орлого	970.8
Үйл ажиллагааны зардал	137.6
Татварын өмнөх ашиг/алдагдал	402.8
Цэвэр ашиг	430.6
Дүрмийн сан	622.8

Бүтэц, зохион байгуулалт

ТУЗ нь нийт 39 гишүүн (давхардсан 1)-ээс бүрдэнэ. Банкны засаглал нь ТУЗ-ийн дарга ба Ерөнхийлөгчийн оффис, ТУЗ, Банкны үйл ажиллагаа хариуцсан дэд захирлын оффис, Менежмент хариуцсан дэд захирлын оффис, Боловсон хүчин хариуцсан дэд захирлын оффис гэсэн бүтэцтэй.

5. The Export Import Bank of Korea – Солонгосын Эксим банк

БНСУ-ын Экспорт-Импортын банк нь экспорт, импортыг нэмэгдүүлэх, хилийн чанад дах хөрөнгө оруулалтын мега төсөл, хөтөлбөрүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар Солонгосын эдийн засгийг хөгжүүлэх, гадаад улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой 1976 онд байгуулагдсан.

Үйл ажиллагааны чиглэл

- Экспортын зээл
- Импортын зээл
- Гадаад бизнесийн зээл
- Шууд бус зээл
- Эдийн засгийн хөгжлийн сурталчилгааны байгууламж
- Баталгаа
- Худалдааны санхүүжилт
- Хөрөнгө оруулалт
- ESG Санхүүжилтийн хөтөлбөр
- Экспортын зээл

Дэмжиж ажиллах салбар

- Дэд бүтэц, үйлдвэрийн санхүүжилт
- Далайн санхүүжилт
- Байгалийн нөөцийн санхүүжилт
- Үйлчилгээний салбарын санхүүжилт
- ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр
- Hidden Champion Initiative
- Санхүүгийн зөвлөгөө, зохицуулалтын үйлчилгээ
- Хилийн чанад дахь зах зээлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр

Санхүүгийн товч мэдээлэл

Сая ам.доллар	2020 он
---------------	---------

Нийт хөрөнгө	82,212.97
Нийт өр төлбөр	70,026.56
Үйл ажиллагааны орлого	1,187.36
Үйл ажиллагааны зардал	753.20
Татварын өмнөх ашиг/алдагдал	110.95
Цэвэр ашиг	82.16
Дүрмийн сан	9,941.28

Бүтэц зохион байгуулалт
ТУЗ-тай, 100% төрийн өмчит байгууллага.

6. Nippon Export Import and investment Insurance – Япон улсын Эксим банк

Япон улсын арилжааны даатгалуудын орхигдуулдаг гадаад гүйлгээний явцад үүсэж болзошгүй эрсдэлийг даатгах зорилгоор анх 2001 онд үүсгэн байгуулагдсан.

Худалдаатай холбоотой даатгалын үйлчилгээний төрөлд далайн даатгал багтдаг. Энэ нь экспортын болон импортын ачааг аяллын явцад устгаж, гэмтээхээс учирсан хохирлыг нөхөн төлдөг даатгал юм.

Экспортын зээлийн даатгал

- ЖДҮ болон AFF салбарын экспортын зээлийн даатгал
- Тодорхой худалдан авагчийн байнгын захиалгад зориулсан худалдааны даатгал
- Хялбаршуулсан журмаар экспортын иж бүрэн даатгал
- Экспортын төлбөрийн даатгал
- Урьдчилсан төлбөрийн импортын даатгал
- Худалдан авагчийн зээлийн даатгал
- Хилийн чанад дахь зээлийн даатгал
- Гадаад дахь хөрөнгө оруулалтын даатгал
- Байгалийн баялаг, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт, зээлийн даатгал

Санхүүгийн товч мэдээлэл

Сая: ам.доллар	2020 он
Нийт хөрөнгө	17,179.69
Нийт өр төлбөр	9,504.20
Үйл ажиллагааны орлого	500.01
Үйл ажиллагааны зардал	511.60
Татварын өмнөх ашиг/алдагдал	0
Цэвэр ашиг	(0.07)

Бүтэц зохион байгуулалт
100% төрийн өмчит байгууллага.

7. The Export-Import bank of India – Энэтхэгийн Эксим банк

Энэтхэгийн Эксим банк 100 хувь төрийн өмчит, эдийн засгийн дипломат бодлогын банк юм. Анх 1982 онд үүсгэн байгуулагдсан. Тус банк нь экспортлогч, импортлогчдод санхүүгийн туслалцаа үзүүлж, улс орны олон улсын худалдааг дэмжих зорилго бүхий бараа үйлчилгээний экспорт, импортын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхэлдэг санхүүгийн байгууллага юм.

Үйл ажиллагааны чиглэл

Банк нь бодлогын банкны үүргийг гүйцэтгэдэг ба ЗГ, төрийн болон хэвийн хэвшлүүдэд холбогдох үйлчилгээг үзүүлдэг.

- Шууд зээл
- Байгууллагын банкны үйлчилгээ
- Зээлийн шугам
- Гадаад худалдааны хөрөнгө оруулалтын санхүү
- Төслийн экспорт
- UBHARTE SITARE программ

Бүтэц зохион байгуулалт

БНЭУ-ын Засгийн газраас ТУЗ-ийн гишүүдийг томилдог бөгөөд тэргүүлэх чиглэлийн яамд (Сангийн яам, Үйлдвэр худалдаа, гадаад харилцааны яам) болон Энэтхэгийн Төв банкны дээд албан тушаалтнуудаас бүрддэг.

Засгийн газрын төлөөлөл:	
Гадаад хэргийн яам	Төрийн нарийн бичгийн дарга
Худалдаа, аж үйлдвэрийн яамны Үйлдвэрлэл, дотоод худалдааг дэмжих газар	Ерөнхий зөвлөх
Сангийн яамны Санхүүгийн үйлчилгээний газар	Нарийн бичгийн дарга
Сангийн яамны Эдийн засгийн газар	Нарийн бичгийн дарга
Худалдаа, аж үйлдвэрийн яам, Худалдаа, аж үйлдвэрийн газар	Нарийн бичгийн дарга
ААН, арилжааны банкнуудын төлөөлөл:	
Энэтхэгийн нөөцийн банк	Гүйцэтгэх захирал
ECGC Ltd. (Экспортын зээлийн үйлчилгээ үзүүлэгч төрийн өмчит компани)	ТУЗ-ийн дарга-Гүйцэтгэх захирал
Энэтхэгийн Төрийн банк	ТУЗ-ийн дарга
IDBI банк (Энэтхэгийн аж үйлдвэрийн хөгжлийн банк)	Гүйцэтгэх захирал
Энэтхэгийн Юнион банк	Гүйцэтгэх захирал
Махараштрагийн банк	Гүйцэтгэх захирал
Үндсэн байгууллагын төлөөлөл:	
Энэтхэгийн ЭКСИМ банк	Гүйцэтгэх захирал
Энэтхэгийн ЭКСИМ банк	Гүйцэтгэх захирлын орлогч

Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоо, хөгжлийн түвшнийг харгалзан үзээд, Румын, Вьетнам, Бразил, Турк, Пакистан, Бангладеш, Энэтхэг, Индонез, Австрали, Филиппин улсын эксим банкны туршлагыг судалсан бөгөөд эдгээр улсуудын эксим банк нь 100 хувь төрийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн зарим улсын эксим банкнууд хөгжлийн банкны үүргийг давхар гүйцэтгэдэг.

НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Иймд асуудлыг шийдвэрлэх дээр дурдсан хувилбаруудтай харьцуулан үзэхэд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл боловсруулах нь илүү үр дүнтэй гэж үзлээ.

Энэ хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үе шатны дагуу санал авч, өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулна.

oOo